



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ЗЭЭЛИЙН ХУВААРИЛАЛТ, ҮР ДҮНД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



АУДИТЫН ДҮН: ЖДҮ-ийг дэмжих сангаас 2014-2016 онд орон нутагт хуваарилагдсан 1,5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 48.7 хувь нь ашиглагдаагүй байна.

БАЯНХОНГОР ХОТ 2017 ОН

АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ГҮЙЦЭТГЭЛИЙН аудитын ТАЙЛАН	4
Тайлангийн хураангуй	5
АУДИТЫН ДҮН	7
Бүлэг 1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014-2016 онд 1.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилж, Хас банкинд байрших тусгай санд аймгийн орон нутгийн орлогоос 2007-2009 онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 75,0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.	7
1.1 Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас Баянхонгор аймагт 2014-2015 онд 1.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилжээ.	7
1.2 Баянхонгор аймгийн Хас банкинд байрших ЖДҮ-ийг хөгжүүлэх тусгай санд 2007-2009 онуудад аймгийн орон нутгийн орлогоос нийт 75.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.	7
Бүлэг 2: ЖДҮ-ийн төслийг сонгон шалгаруулахдаа дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, санал өгөөгүйгээс дэмжигдсэн төслүүд арилжааны банкны шалгуурыг хангахгүй байна.	9
2.1. ЖДҮ хөгжүүлэх, ажлын байр бий болгох төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг журмын дагуу зохион байгуулжээ.	9
2.2. ЖДҮ-ийн төслийг хүлээн авах талаар 2014, 2015 онуудад орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлжээ.	10
2.3. ЖДҮ-ийн төслийг сонгон шалгаруулахдаа дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, санал өгөөгүй, дэмжигдээгүй төслийн талаар тайлбар тодруулга гаргаагүй байна.	10
Бүлэг 3. ЖДҮХСангаас арилжааны банкаар дамжуулан 807.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 25 зээлдэгчийн 92 хувь нь үйл ажиллагаа явуулсны үр дүнд 51 ажлын байр хадгалагдаж, 68 ажлын байр шинээр бий болсон нь ЖДҮХС-гийн зээл нь орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулахад зохих үр дүн өгчээ.	13
3.1. Дэд комиссоос 2014-2016 онд сонгон шалгаруулж дэмжигдсэн 38 төслөөс арилжааны банкны шаардлага хангаагүйгээс 13 төсөлд хөнгөлөлттэй зээл олгогдоогүй нь хуваарилагдсан эх үүсвэрийн 48.7 хувийг ашиглах боломжийг алджээ.	13
3.2 ЖДҮ-ийг дэмжих сангаас 807.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 25 зээлдэгчээс 2 зээлдэгч зээлийн 95,0 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.	14
3.3. 2012-2016 онд олгосон ЖДҮ-ийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн үр дүнд 51 ажлын байр хадгалагдаж, 68 ажлын байр шинээр бий болжээ.	18
АУДИТЫН ДҮГНЭЛТ	Error!
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ХХК	Хязгаардлагдмал хариуцлагатай компани
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
СХС	Сум хөгжүүлэх сан

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1а/399 тоот албан бичгээр ирүүлсэн захиалга, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдэгдэл

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвөөс 2014-2016 онд олгосон хөрөнгө, түүний зарцуулалт, үр дүнд шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын ерөнхий зорилт чиглэгдэв. Дээрхи ерөнхий зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ЖДҮ –ийг дэмжих сангийн хөрөнгийн бүрдүүлэлт
- ЖДҮ–ийг дэмжих сангаас олгосон зээлийн төслийн сонгон шалгаруулалт журмын дагуу явагдсан эсэх.
- ЖДҮ хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт, үр нөлөө

Аймгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн 2014-2016 оны санхүүгийн баримт материал, үйл ажиллагааны тайлан, дамжуулан зээлдүүлж буй Баянхонгор аймаг дахь Хаан, Хас, Голомт банкуудаас авсан мэдээ тайлан, холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

3. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд, зээлд хамрагдсан бизнес эрхлэгчдтэй ярилцлага хийх, лавлагаа тодруулга авч, холбогдох зураг авалт хийн, нотлох баримтад тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийв.

4. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор А.Цээням, аудитор М.Алтантуяа, Б.Азбаяр нар гүйцэтгэв.

5. Аудит хийсэн хугацаа

Аудитыг 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр эхэлж, 06 дугаар сарын 8-ний өдөр дуусгаж, аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулав.

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.

ЖДҮ-ийг дэмжих зорилгоор ЖДҮХС-гаас 2014 онд 1,0 тэрбум төгрөг хуваарилснаас 9 төсөл хэрэгжүүлэгчид 387.5 сая төгрөг, 2015 онд 500.0 сая төгрөг хуваарилснаас 8 төсөл хэрэгжүүлэгчид 307.7 сая, 2015 онд дэмжигдсэн 1 төсөлд 50,0 сая төгрөгийн зээлийг 2016 онд олгосон, 2016 онд ЖДҮХС-гаас аймгийн ЖДҮ-г дэмжих санд хөрөнгө хуваарилагдаагүй байна.

2007-2009 онуудад Баянхонгор аймгийн орон нутгийн төсвөөс Хас банкны төвд байршуулсан ЖДҮХС-гийн 75,0 сая төгрөгийн эх үүсвэрээс 2016 онд 7 төсөл хэрэгжүүлэгчид 62.4 сая төгрөгийн зээлийг Хас банкаар дамжуулан олгожээ.

Аудитаар 2014-2016 онуудад арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 25 төсөл хэрэгжүүлэгчийн үйлдвэрлэл, үйлчилгээтэй танилцахад 2 зээлдэгч төслийн зээлийг зориулалт бусаар ашиглаж үйл ажиллагаа явуулаагүй байна. Тухайлбал:

- ЖДҮДСангаас “Их Ганзүү” ХХК-ны захирал Ж.Ганзул “Олс, олсон бүтээгдэхүүн үйлдвэрлэх” зориулалтаар 70,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны Хас банкаар дамжуулан 2014 оны 9-р сарын 22-ны өдөр авсан боловч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй.
- “Цаглашгүй хүрд” ХХК “Баянхонгор бренд бүтээгдэхүүн” модон сийлбэр эдлэл үйлдвэрлэх зориулалтаар 25,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны Хас банкаар дамжуулан 2014 оны 12-р сарын 09-ны өдөр авсан боловч зээлийн хөрөнгөөр төсөлд тусгасан сийлбэрийн тоног төхөөрөмж, машиныг худалдан аваагүй, 2016 оны 3-р сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

Энэ нь зээлдэгчийн Хас банкт байгуулсан зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3, Аж үйлдвэрийн сайдын 2015.03.25-ны 64 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.5 дахь заалтуудыг зөрчсөн тул зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөөгүй үлдэгдэл “Их Ганзүү” ХХК-ний 42,3 сая, “Цаглашгүй хүрд” ХХК-ийн 15,6 сая төгрөгийг арилжааны банкны зээлд шилжүүлэн, Хас банкнаас ЖДҮДСанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитаар ЖДҮ-ийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгч нарыг Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан эсэх давхардлыг шалгахад “Төгс төгөлдөр үйлс” ХХК нь Баянхонгор аймгийн Сум

хөгжүүлэх сангаас 2014 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 20,0 сая төгрөг авч, зээлийг төлж дуусаагүй байхад 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Хас банкнаас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 40,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг давхардуулан олгожээ.

“Төгстөгөлдөр үйлс” ХХК-ийн 2017.05.30-ны байдлаархи Баянхонгор сумын СХС-гаас авсан зээлийн үлдэгдэл 10825,0 мянган төгрөгийг санд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Хас банкин дахь Тусгай санд 2007-2009 онд орон нутгийн орлогоос байршуулсан 75,0 сая төгрөгийн аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т заалтыг зөрчсөн тул авлагаар тусгуулахаар албан шаардлага хүргүүлэв.

Хас банкин дахь Тусгай санд байршуулсан 75,0 сая төгрөгт 2007 оноос эхлэн жилийн 1.2 хувийн хүү тооцогдсоор 2017 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 6,9 сая төгрөгийн хүү бодогдсон ба гэрээнд хүүгийн орлогыг хэрхэн зарцуулах, ашиглах талаар тодорхой заалт тусгаагүй байна.

Иймд аудитаар Хас банкны тусгай санд байрших хүүгийн орлогын 6,9 сая төгрөгийг Орон нутгийн орлогод татан төвлөрүүлэхээр шийдвэрлэж, төлбөрийн акт тогтоов.

Аудитаар нийт 150.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах талаар 75.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 75.0 сая төгрөгийн албан шаардлага бичигдсэн ба зохион байгуулалтын 1, хууль журмыг хэрэгжүүлэх 4, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1, нийт 6 зөвлөмж өглөө.

АУДИТЫН ДҮН

Бүлэг 1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014-2016 онд 1.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилж, Хас банкинд байрших тусгай санд аймгийн орон нутгийн орлогоос 2007-2009 онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 75,0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

1.1 Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас Баянхонгор аймагт 2014-2015 онд 1.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилжээ.

Хөдөлмөрийн сайдын 2014 оны 118 дугаар тушаалаар баталсан “ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах гэрээ”-г Баянхонгор аймгийн Засаг дарга, ЖДҮ хөгжүүлэх сангийн захирал, аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга нар 2014.05.31-ний өдөр байгуулжээ.

Монгол улсын Засгийн газраас Эдийн засгийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлыг эрчимжүүлэх зорилгоор ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс Баянхонгор аймагт 2014 онд 1.0 тэрбум, 2015 онд 500.0 сая төгрөг хуваарилж, 2016 онд хөрөнгө хуваарилаагүй байна.

1.2 Баянхонгор аймгийн Хас банкинд байрших ЖДҮ-ийг хөгжүүлэх тусгай санд 2007-2009 онуудад аймгийн орон нутгийн орлогоос нийт 75.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Аймаг, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээг 2007.05.28-ны өдөр Үйлдвэр, худалдааны сайд Ц.Даваадорж, Баянхонгор аймгийн Засаг дарга П.Зоригтбаатар, Хас банкны гүйцэтгэх захирал Д.Ганхуяг нар байгуулжээ. Тус гэрээний 2-т “ЖДҮ-ийн дэмжих сангийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг эх үүсвэрийг банкин дахь “Тусгай зориулалтын сан”-д байршуулна”, 6.1-т “Банк нь Үйлдвэр худалдааны Яам болон аймгийн ЗДТГ-аас байршуулсан эх үүсвэрийн мөнгөн хөрөнгийг Тусгай зориулалтын санд гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш 1 сарын дараа буцаан шилжүүлнэ. Тусгай сангийн ашиглагдаж байгаа хэсгийг Банк өөрийн эх үүсвэрээр хааж, ҮХЯ, аймгийн ЗДТГ-т бүрэн дүнгээр шилжүүлэх”-ээр тусгасан байна.

Дээрх гэрээний дагуу Баянхонгор аймгийн Хас банкин дахь Тусгай зориулалтын санд Баянхонгор сан, Орон нутгийн орлогоос нийт 75.0 сая төгрөгийг байршуулсан байна. Үүнд:

ЖДҮ-ийг дэмжих тусгай санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө

/Сая,төг/

№	2007 он	2008 он	2009 он	Нийт дүн
Баянхонгор сан	10,0			10,0
Орон нутгийн орлогоос	15,0	30,0	20,0	65,0
Дүн	25,0	30,0	20,0	75,0

Хамтран ажиллах дээрхи гэрээнд 2016.10.24-нд аймгийн Засаг дарга Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ихбаяр, Хас банкны захирал Г.Олонбаяр нар нэмэлт өөрчлөлт оруулж, хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан тусгай сангийн хөрөнгийг 2021.10.17-ны өдөр хүртэл Хас банкинд байршуулахаар хугацааг сунгасан байна.

Хас банкин дахь Тусгай санд байршуулсан 75,0 сая төгрөгт 2007 оноос эхлэн жилийн 1.2 хувийн хүү тооцогдсоор 2017 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 6,9 сая төгрөгийн хүү бодогдсон ба гэрээнд хүүгийн орлогыг хэрхэн зарцуулах, ашиглах талаар тодорхой заалт тусгаагүй байна.

Иймд аудитаар Хас банкны тусгай санд байрших хүүгийн орлогын 6,9 сая төгрөгийг Орон нутгийн орлогод татан төвлөрүүлэхээр шийдвэрлэж, төлбөрийн акт тогтоов.

Мөн ЖДҮ дэмжихээр тусгай зориулалтын санд орон нутгийн орлогоос төвлөрүүлсэн 75,0 сая төгрөгийн тусгай сангийн хөрөнгийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2¹ дахь заалтыг зөрчсөн тул тусгай санд эргэн төлөгдөх нөхцлөөр байршуулсан 75,0 сая төгрөгийг бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч нарт хүргүүлэв. Цаашид Тусгай зориулалтын санд байршиж байгаа

¹ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2¹-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг Нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ"

хөрөнгийн хүүгийн орлогыг хэрхэн зарцуулах талаар шийдвэр гаргаж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг аймгийн ИТХ-ын даргад зөвлөмжөөр өгөв

Бүлэг 2: ЖДҮ-ийн төслийг сонгон шалгаруулахдаа дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, санал өгөөгүйгээс дэмжигдсэн төслүүд арилжааны банкны шалгуурыг хангахгүй байна.

2.1. ЖДҮ хөгжүүлэх, ажлын байр бий болгох төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг журмын дагуу зохион байгуулжээ.

Хөдөлмөрийн сайдын 2013.03.19-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар батлагдсан “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 4.2²-дахь заалтыг үндэслэн Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013.03.27-ны өдрийн хуралдааны 58 тоот тогтоолоор ЖДҮ-ийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссыг /цаашид дэд комисс гэх/ 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, дэд комиссын үйл ажиллагааны журмыг баталжээ.

2014-2015 онд дээрх томилогдсон дэд комисс ЖДҮ-ийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалтыг явуулсан байна.

Аж үйлдвэрийн сайдын 2015.03.25-ны өдрийн 64 тоот тушаалаар “Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны журам”-ыг шинэчлэн баталсан байхад аймаг 2015 онд төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг шинэчлэн байгуулаагүй байна.

Харин аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016.10.26-ны өдрийн 96 тоот тогтоолоор ЖДҮ-ийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих дэд комиссын даргаар аймгийн Засаг дарга Г.Батжаргал, дэд даргаар АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ихбаяр, гишүүдээр ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Б.Оюунцэцэг, аймгийн ХХААГ-ын дарга Ж.Баттөр, Хас банкны салбарын захирал Г.Олонбаяр нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

² “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 4.2-т “... дэд комисс нь нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 9-13 хүний бүрэлдэхүүнтэй байна”

2.2. ЖДҮ-ийн төслийг хүлээн авах талаар 2014, 2015 онуудад орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлжээ.

ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох төслийг хүлээн авах хугацааг нийтэд дараах байдлаар мэдээлсэн байна. Үүнд:

2014 онд “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.1³–д заасны дагуу аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс төсөл хүлээн авах зарыг 06 дугаар сарын 13-наас эхлэн 7 хоног, 2015 онд “Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны журам”-ын 4.1-д заасны дагуу 03 –р сарын 30-наас 14 хоногийн хугацаанд орон нутгийн TV-10 телевизээр зар өгсөн байна.


Харин 2016 онд Хас банкинд байрших ЖДҮ-ийн дэмжих тусгай сангийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах төслийг хүлээн авах талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл телевиз, сониноор мэдээлээгүй байна.

2.3. ЖДҮ-ийн төслийг сонгон шалгаруулахдаа дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, санал өгөөгүй, дэмжигдээгүй төслийн талаар тайлбар тодруулга гаргаагүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журам”-ын 2.2-т “Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарласнаас эхлэн төсөл хүлээн авч дуусах эцсийн хугацаа хүртэл Хөдөлмөрийн хэлтсийн ЖДҮ хариуцсан мэргэжилтнүүд, ЖДҮ эрхлэгчдээс ирүүлсэн төслийг бүртгэн, ирсэн дарааллын дагуу хүлээн авч, хүлээн авсан цаг хугацааг баталгаажуулан гарын үсэг зурж хүлээж авна” гэж заасны дагуу 2014 онд 4033,9 сая төгрөгийн 38 төсөл, 2015 онд 4218,9 сая төгрөгийн 40 төсөл хүлээн авснаас томоохон 2 төслийг журмын дагуу ЖДҮ-ийн санд албан тоотоор хүргүүлж, 2016 онд 29 төсөл хүлээн авчээ.

Ирүүлсэн төслийг салбараар нь ангилж үзвэл:

³ “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.1³–д “Дэд комиссийн шийдвэрээр хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хүссэн төслүүдийг хүлээн авах хугацааг тохирч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх үүргийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэс хариуцна”



Хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд комисс нь аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл гэж үзэн ХАА-ын түүхий эд боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэл, оёдлын үйлдвэрлэл, аялал жуулчлал, рашаан сувилал зэрэг салбаруудыг голчилсон бөгөөд төсөл сонгон шалгаруулахдаа ажлын байр нэмэгдүүлэх, зах зээлийн судалгаа хийгдсэн хэрэгжих боломжтой төслүүдийг сонгон шалгаруулах бодлого баримталжээ.


Дэд комисс нь 2014 оны 7-р сарын 30-ны өдөр хуралдан нийт 4033,8 сая төгрөгийн 38 төслөөс 551,9 сая төгрөгийн 9 төслийг, мөн 2014 оны 09-р сарын 08-ний өдрийн хуралдаанаар 437,0 сая төгрөгийн 9 төслийг, 2015 оны 6-р сарын 09-ний өдрийн хуралдаанаар нийт 2635,6 сая төгрөгийн 39 төслөөс 500,0 сая төгрөгийн 11 төслийг тус тус сонгон шалгаруулан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг дамжуулан зээлдүүлэхээр гэрээ байгуулсан Хас, Хаан, Голомт банкуудад хүргүүлсэн байна.

Төслийн шаардлага хангаагүй, арилжааны банкинд хэт өндөр зээлтэй, эрхлэх үйл ажиллагаа нь тодорхой бус, ирүүлсэн төсөл нь ойлгомжгүй зэрэг шалтгааны улмаас 2014 онд 27 төсөл, 2015 онд 20 төслийг буцаахдаа Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 64 тоот тушаалаараар батлагдсан “Төсөл сонгон шалгаруулах хороо болон дэд хорооны журам”-ын 4.3 дахь заалтын дагуу иргэн, хуулийн этгээдэд албан бичгээр хүргүүлээгүй байна.

Төслийн сонгон шалгаруулалтын хуралдааны тэмдэглэлтэй танилцахад дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, санал өгсөн тухай бичээгүй, хурлын тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтлөөгүй байна.

Мөн банкнаас дэд комисст буцаасан төслүүдэд төсөл хүлээлцсэн акт үйлдээгүй байна.

Дэд комиссын сонгон шалгаруулсан төслийг салбарын ангиллаар нь харуулбал:



Аудитаар ЖДҮ-ийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгч нарыг Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан эсэх давхардлыг шалгахад “Төгс төгөлдөр үйлс” ХХК нь Баянхонгор аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2014 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 20,0 сая төгрөг авч, зээлийг төлж дуусаагүй байхад 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Хас банкнаас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 40,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг давхардуулан олгожээ.

“Төгс төгөлдөр үйлс” ХХК-ийн 2017.05.30-ны байдлаархи Баянхонгор сумын СХС-гаас авсан зээлийн үлдэгдэл 10825,0 мянган төгрөгийг санд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжид давхардуулан олгож байгаа нь Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн мэдээллийг авдаггүй, ЖДҮ эрхлэгчдийн мэдээлэл, судалгаа байхгүйгээс дэд комисс төслийг шалгаруулж, арилжааны банкууд зээл олгожээ. Цаашид энэ талаар анхаарч ажиллах талаар зөвлөмж өгөв.

2016 онд тусгай сангийн эх үүсвэрээс ЖДҮ-ийг дэмжих зээл олгохтой холбогдуулан 2007 онд банкт байгуулсан хамтран ажиллах гэрээнд “ЖДҮ-ийг дэмжих тусгай сангаас 1 зээлдэгчид 15,0 сая хүртэлх төгрөгийн зээлийг 3 хүртэл жилийн хугацаатай олгох” –оор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2016 онд 3700,5 сая төгрөгийн 29 төсөл хүлээн авснаас дэд комисс нь нийт 78,0 сая төгрөгийн 9 төслийг сонгон шалгаруулан хөнгөлөлттэй зээлд хамруулах хүсэлтийг Хас банкинд уламжилсан байна.

**Төслийн хөнгөлөлттэй зээл авахаар төсөлд тусгагдсан
дүнг Дэд комиссоос дэмжигдсэн дүнтэй харьцуулбал**

Салбарын ангилал /сая төгрөг/	2014		2015		2016	
	Төслийн хөнгөлөлттэй зээл авахаар төсөлд тусгагдсан дүн	Дэд комиссоос дэмжигдсэн дүн	Төслийн хөнгөлөлттэй зээл авахаар төсөлд тусгагдсан дүн	Дэд комиссоос дэмжигдсэн дүн	Төслийн хөнгөлөлттэй зээл авахаар төсөлд тусгагдсан дүн	Дэд комиссоос дэмжигдсэн дүн
Хүнсний үйлдвэрлэл	66.2	54.2	240.0	120.0	20.0	20.0
Хөнгөн үйлдвэр	507.6	410.0	96.0	60.0	33.1	33.1
Барилгын материалын үйлдвэрлэл	465.6	302.6	202.0	105.1		
Мал аж ахуй, газар тариалан	136.2	136.2	89.8	40.0		
Бусад	86.0	86.0	273.1	174.9	24.9	24.9
Нийт	1,261.6	989.0	900.90	500.00	78.00	78.00

Бүлэг 3. ЖДҮХСангаас арилжааны банкаар дамжуулан 807.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 25 зээлдэгчийн 92 хувь нь үйл ажиллагаа явуулсны үр дүнд 51 ажлын байр хадгалагдаж, 68 ажлын байр шинээр бий болсон нь ЖДҮХС-гийн зээл нь орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулахад зохих үр дүн өгчээ.

3.1. Дэд комиссоос 2014-2016 онд сонгон шалгаруулж дэмжигдсэн 38 төслөөс арилжааны банкны шаардлага хангаагүйгээс 13 төсөлд хөнгөлөлттэй зээл олгогдоогүй нь хуваарилагдсан эх үүсвэрийн 48.7 хувийг ашиглах боломжийг алджээ.

ЖДҮ-ийн төсөл сонгон шалгаруулах дэд комисс нь 2014-2016 онд нийт 1567.0 сая төгрөгийн 38 төслийг сонгон шалгаруулж, арилжааны банкинд хүргүүлснийг арилжааны банк судлан 25 төсөлд 807.6 сая төгрөгийн зээл олгожээ.

Дэд комиссоос дэмжигдсэн болон олгосон зээлийн харьцуулалт /сая,төг/

Он	Дэд комиссоос дэмжигдсэн		Арилжааны банкнаас төсөлд олгосон зээл		Зөрүү
	тоо	Дүн	тоо	Дүн	
2014	18	989.0	10	395.2	593.8
2015	11	500.0	8	350.0	150.0
2016	9	78.0	7	62.4	15.6
Дүн	38	1567.0	25	807.6	759.4

Арилжааны банк нь зээлийн судалгаа хийж дэд комиссоос дэмжигдсэн 691.2 сая төгрөгийн 13 төсөлд зээл олгоогүй, 8 төслөөс 68.2 сая төгрөгийг зээлийг бууруулж нийт дэмжигдсэн дүнгээс 759.4 сая төгрөгийн зээлийг олгоогүй байна.

Энэ шалтгааныг банкны эдийн засагч нараас тодруулахад “банкинд мөрдөгддөг зээлийн журам, зааварт заасан шаардлага хангаагүй, үйл ажиллагаа тогтмол биш, орлого, зарлагын харьцаа зохистой бус, барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй, зарим төсөл хэрэгжүүлэгчийн зээлийн материалыг зээлийн батлан даалтын сан руу явуулсан боловч дэмжигдээгүй зэргээс хамаарч дэмжигдсэн дүнгээс зээл хасч олгосон” гэсэн тайлбарыг өгөв.

ЖДҮ-ийг дэмжих сангаас 2014-2016 онд хуваарилсан 1.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрээс арилжааны банкаар дамжуулан 2014 онд 9 төсөлд 387.5 сая, 2015 онд 8 төсөлд 307.7 сая, 2015 онд дэмжигдсэн 1 төсөлд 50.0 сая төгрөгийг 2016 онд олгосон байна. Мөн 2016 онд ЖДҮ хөгжүүлэх тусгай санд аймгийн орон нутгийн орлогоос Хас банкны Тусгай санд байршуулсан 75.0 сая төгрөгийн эх үүсвэрээс 7 төсөлд 62.4 сая, 2017 онд 1 төсөлд 3.0 сая төгрөгийг олгож, үлдэгдэл 9.6 сая төгрөгийн эх үүсвэрээс зээл олгоогүй байна.

ЖДҮ-ийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгийн эх үүсвэрээс 51.3 хувь буюу 807.6 сая төгрөгийн зээл олгосон нь хуваарилсан эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна.

Арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй
зээлийг банк тус бүрээр авч үзвэл:

№	Зээл олгосон он	Нийт дүн /сая төгрөг/		Үүнээс:					
		Зээлдэгчийн тоо	Дүн	ХАС банк		ХААН банк		Голомт банк	
				тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	2014 он	9	387.5	7	332.5	1	20.0	1	35.0
2	2015 он	8	307.7	6	250.0	2	57.7	0	0
3	2016 он	8	112.4	8	112.4				
	Дүн	25	807.6	21	694.9	3	77.7	1	35.0


ЖДҮ-ийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээлийг олгосоноор зээл, зээлийн хүү эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөж байна.

3.2 ЖДҮ-ийг дэмжих сангаас 807.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 25 зээлдэгчээс 2 зээлдэгч зээлийн 95,0 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.

ЖДҮ-ийн сангаас зээл авсан нийт 25 зээлдэгчээс Баянговь, Жаргалант сумдад үйл ажиллагаа явуулж буй 2 зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцаагүй ба бусад 23 зээлдэгчийн үйл ажиллагааг газар дээр нь очиж шалгалаа.

Аудитаар 16 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа хэвийн, /үүнээс 10 зээлдэгч улирлын чанартай/, 3 төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаа явуулж байгаа боловч төсөлд тусгагдсан зарим тоног төхөөрөмжийг аваагүй, 2 төсөл хэрэгжүүлэгч нь зарим хөрөнгийг бэлтгэсэн хэдий ч үйл ажиллагаа явуулж эхлээгүй, 2 төсөл хэрэгжүүлэгч төслийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй зориулалт бусаар зарцуулсан байв.

Зээлийн хөрөнгийн зарцуулалтыг хүснэгтээр нэгтгэн харуулвал:



3.2 а.Үйл ажиллагаа хэвийн явуулж байгаа:

2014-2016 онд хөнгөлөлттэй зээлд хамрагдан 530.4 сая төгрөгийн зээл авсан 16 зээлдэгчийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаагаас 189.9 сая төгрөгийн зээл авсан 6 зээлдэгч байнгын, 340.5 сая төгрөгийн зээл авсан 10 зээлдэгч улиралын чанартай ажиллаж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал: сая. төг

№	Зээлдэгчийн нэр	Төслийн үйл ажиллагааны чиглэл	Зээл олгосон огноо	Олгосон зээлийн хэмжээ	№	Зээлдэгчийн нэр	Төслийн үйл ажиллагааны чиглэл	Зээл олгосон огноо	Олгосон зээлийн хэмжээ
1	Чулуундорж Пүрэвсүрэн	Мод, модон эдлэл	2014.09.22	40.0	9	Бямбаа Намжилмаа	Оёдлын үйлдвэр	2014.12.31	35.0
2	Пунцаг Энхбат	Хаяа худагт "гахайн аж ахуй" эрхлэх	2014.09.22	30.0	10	Самдан Амарбаяр	Блок үйлдвэрлэл	2015.08.25	55.1
3	Жанчив Сарнай	Хүүхдийн болон спорт хувцас үйлдвэрлэл	2015.08.25	25.0	11	Нямбуу Түвшин	Мал амьтны гаралтай үслэг эдлэл боловсруулах	2015.08.26	25.0
4	Загд Шарав	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2015.08.25	70.0	12	Бат-очир Түвшинбаяр	Жуулчиний бааз байгуулах	2015.08.27	24.9
5	Наянтай Мэндбаяр	Бууз баншны цех	2016.12.08	15.0	13	Шомбон Лхамноржин	Явган замын хавтан блок үйлдвэрлэл	2016.04.08	50.0
6	Дулам Отгон	Мал эмнэлэгийн үйл ажиллагаа	2016.12.13	9.9	14	Зэвэг Дондогмаа	Үслэг эдлэл оёдол	2016.12.06	4.0
7	Дадъяат Норжин	Сувилал, эмчилгээ үйлчилгээ	2014.09.22	86.0	15	Батжаргал Оюунцэцэг	Монгол үндэсний дээл хувцас оёх	2016.12.07	4.5
8	Банзрагч Дашзэвэг	"дэгжин кашмер" ноос ноолуур эдлэлийн бэлэн хувцасны төсөл	2014.12.08	41.5	16	Зундуй Үржиндорж	Гагнуур хийх	2016.12.12	14.5
Нийт дүн									530.4

3.2 б.Үйл ажиллагаа явуулж байгаа боловч төсөлд тусгагдсан зарим тоног төхөөрөмжийг аваагүй:

1. **“Төгстөгөлдөр үйлс”ХХК** нь төмөр эдлэл, хайс, хашаа зэрэг ган хийц бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр 2014 онд 94.6 сая төгрөгийн төслөөс зээлийн хөрөнгөөр 80.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан боловч дэд комисс зээлийн санхүүжилтийг 50 хувиар бууруулж 40.0 сая төгрөгөөр зээлийг дэмжсэнээр зээл олгосон байна. Зээлдэгч төсөлд тусгагдсан тоног төхөөрөмжийг худалдан авахад мөнгө хүрэлцэхгүй учраас зээлийн 10.0 сая төгрөгийг буцаан төлж, үлдсэн 30.0 сая төгрөгөөр жижиг оврын суурин тасдагч, гагнуурын аппарат зэрэг тоног төхөөрөмж, түүхий эд материалыг худалдан авч, хайс, хашаа, хаалга зэргийн төмөр хийцийг хийж үйл ажиллагааг төсөлд бичсэн зориулалтаар ашиглаж байна.

2. **Л.Одонтунгалаг** нь хэрчсэн гурил, гоймонгийн үйлдвэрийн шугам авч суурилуулах зорилгоор 2015 онд 120.0 сая төгрөгийн үүний 90.0 сая төгрөгийг хөнгөлөлттэй зээл авахаар төсөл бичсэн байна. Дэд комиссоос 50.0 сая төгрөгөөр дэмжигдсэн бөгөөд төсөлд заасан тоног төхөөрөмжийг авч хүрэлцээгүй тул ажлын байрыг өргөтгөн талх, нарийн боовны үйлдвэрийн зориулалтаар засварлан, талх, боов үйлдвэрлэх шарагч шүүгээ болон бусад тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагааг төсөлд заасан чиглэлээр явуулж байна.

3. **“Сүлжээний хөтөч” ХХК** нь 9.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2016.12.28-нд авсан ба төслийн хөрөнгөөр хэвлэлийн " SB750" шарах машин, "qzx 230bz" тасдагч машин, IR 2520 авахаар заасан байсан боловч одоогоор аваагүй гурван үйлдэлт принтер 4.5 сая, принтерийн хор цэнэглэгч машиныг 3.0 сая төгрөгөөр худалдан авчээ. Зээлдэгч нь Баруун бүс худалдааны төвд 20м2 талбай бүхий 1164-р лангууг түрээслэн хэвлэлийн канон, кино хувилах, компьютер засвар, бүх төрлийн хор цэнэглэх үйл ажиллагааг эрхэлж байна.

3.2.в:Төсөлд тусгасан зарим хөрөнгийг бэлтгэсэн хэдий ч үйл ажиллагаа явуулж эхлээгүй :

1. **С.Талстболор** нь Хоёрдогч түүхий эд боловсруулахаар тоног төхөөрөмж худалдан авч, агуулах барихаар нийт 151.5 сая төгрөгийн 93.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авах төсөл бичсэн ба дэд комиссын шийдвэрээр 50.0 сая төгрөгөөр дэмжигдэж 60 сарын хугацаатай хөнгөлөлттэй зээлийг 2015.08.25-нд авчээ. Төслийн хөрөнгөөр түүхий эд боловсруулах зориулалтаар БНХАУ-аас угаагч ванн, 2 ш конвер, бутлагч, хатаагч зэрэг тоног төхөөрөмжийг нийт 35.0 сая, зориулалтын

8000 ширхэг уутыг 2.4 сая төгрөгөөр худалдан авсан байна. Зээлдэгч нь хоёрдогч түүхий эдийг худалдан авч нөөцөлсөн боловч эцсийн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг аваагүй байгаагаас эсцийн бүтээгдэхүүн хийх бололцоогүй зогсонги байдалтай байна.

2. **Д.Нямхүү нь** Бууз баншны цех ажиллуулах зорилгоор 2016.12.06-нд 5.0 сая төгрөгийн зээл авч 1.5 сая төгрөгөөр 3 ш хөргөгч хөлдөөгч авч үйл ажиллагаа явуулж байгаа боловч борлуулалт муу байгаагаас үйл ажиллагаа тогтмолжоогүй байна.

Иймд төсөлд тусгагдсан үйл ажиллагаагаа 2017.10.01-ны дотор явуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэнд зөвлөмж хүргүүлэв.

3.2.г. Үйл ажиллагааг явуулаагүй:

1. **“Их Ганзүү” ХХК** нь “Олс, олсон бүтээгдэхүүн үйлдвэрлэх” зориулалтаар 70,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2014 оны 9-р сарын 22-ны өдөр авч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, төсөлд тусгагдсан үйл ажиллагааг явуулаагүй байна.

2. **“Цаглашгүй хүрд” ХХК** нь “Баянхонгор бренд бүтээгдэхүүн” модон сийлбэр эдлэл үйлдвэрлэх зориулалтаар 25,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2014 оны 12-р сарын 09-ны өдөр авсан боловч зээлийн хөрөнгөөр төсөлд тусгасан сийлбэрийн тоног төхөөрөмж, машиныг худалдан аваагүй, 2016 оны 3-р сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

Энэ нь зээлдэгчийн Хас банктай байгуулсан зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3⁴, Аж үйлдвэрийн сайдын 2015.03.25-ны 64 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.5⁵ дахь заалтуудыг зөрчсөн тул зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөөгүй үлдэгдэл “Их Ганзүү” ХХК-ний 42,3 сая, “Цаглашгүй хүрд” ХХК-ийн 15,6 сая

⁴ Зээлдэгчийн Хас банктай байгуулсан зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3-т “Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Үндсэн гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тохиолдолд зээлийг нэн даруй буцаан төлүүлэх эсхүл зээлийн хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж, тухайн үед Банкинд нийтэд зарласан бизнесийн зээлийн дээд хүүд шилжүүлнэ. Зээлийн хүүд өөрчлөлт оруулсан нь зээлийн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах үндэслэл болно”

⁵ Аж үйлдвэрийн сайдын 2015.03.25-ны 64 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.5-д “Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг ажлын хэсэг газар дээр нь шийдвэрлэн ажиллах ба зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль дүрэм журам зөрчиж олгосон зэрэг нь хяналт, шалгалтын байгууллага, яамны хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр буцаан төвлөрүүлнэ”

төгрөгийг арилжааны банкны зээлд шилжүүлэн, Хас банкнаас ЖДҮДСанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн нь ЖДҮ-ийг дэмжих сангаас олгосон зээлдэгч нарын төслийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, мэдээ тайланг журмын дагуу гаргаж албажуулаагүй байгаа нь тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг ХХААГ-ын даргад хүргүүлэв.

Цаашид ЖДҮДСангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгч нарын зээлийн зориулалт, ашиглалтад жилд 1-ээс доошгүй удаа хяналт тавьж, тайланг танилцуулан үр дүнг хэлэлцүүлж байхыг ХХААГ-ын дарга, мэргэжилтэн нарт зөвлөв.


3.3. 2012-2016 онд олгосон ЖДҮ-ийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн үр дүнд 51 ажлын байр хадгалагдаж, 68 ажлын байр шинээр бий болжээ.

2014-2016 онд ЖДҮ-ийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 25 зээлдэгч үйл ажиллагаа явуулж 143 ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс 23 зээлдэгч үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсны үр дүнд хадгалагдсан 51, шинээр 68 ажлын байр нэмэгдэж байгаагаас үзэхэд ЖДҮХС-ийн зээл нь ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулахад зохих үр дүн өгч байна.

Дээрх ажлын байрыг шинж чанараар нь ангилан авч үзвэл байнгын ажлын байр 72, улиралын чанартай ажлын байр 46, түр ажлын байр 1 байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн нь ажлын байрны мэдээг тухай бүрт нь хүргүүлж ажилладаг гэх боловч аудитын явцад албажуулж баталгаажуулсан мэдээ байхгүй байна. Иймд цаашид Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 64 тоот тушаалаар батлагдсан журмын 6.3-т заасан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан улсын хэмжээнд олгосон зээлийн хөнгөлөлттэй зээлийн дэлгэрэнгүй мэдээг сар бүр, улирал бүрийн тайланг дараа сарын 5-ны дотор Яамны удирдлагууд болон холбогдох газарт ирүүлнэ” гэсэн заалтыг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

2012-2016 онд олгосон ЖДҮ-ийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн үр дүнд Баянхонгор аймагт уламжлалт болон шинээр 17 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, иргэдэд 3 төрлийн үйлчилгээ үзүүлж байна.



Төсөл хэрэгжүүлсний үр дүнд шинээр хийж буй бүтээгдэхүүнээс үр ашгаа өгч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ нилээд байна. Үүнд:

- Иргэн Д.Норжингийн хэрэгжүүлж байгаа “Бага шаргалжуут” рашаан сувилалын үйлчилгээнд жилд 280-430 хүн тогтмол үйлчлүүлдэг. Эмчилгээ сувилгааны чиглэлээр үйл ажиллагаа тогтворжсон 2017 онд цахилгааны эх үүсвэрт холбогдохоор Шаргалжуутын царилгааны шугамаас 4.5 км цахилгаан дамжуулах шугам татаж байна.



- Иргэн З.Шаравын хэрэгжүүлж байгаа "Жаргант хүнс хиаман цех" нь хоногт 3 тн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай, одоогийн байдлаар 7 хоногт дунджаар 300 кг, 12 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутгийн 50-60 дэлгүүрт тогтмол нийлүүлэлт хийж байна.



- Иргэн Ш.Лхамноржин 2016 онд 10000 ширхэг блок, явган замын хавтан 3000 ширхэг, эко хавтан 6000 ширхэгийг үйлдвэрлэж орон нутгийн хэрэгцээнд нийлүүлсэн байна.



Аудитаар нийт 150,7 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 75,7сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 75,0 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014-2016 онд 1.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилж, аймгийн орон нутгийн орлогоос 2007-2009 онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 75,0 сая төгрөгийг Хас банкинд байрших тусгай санд байршуулснаас нийт эх үүсвэрийн 48.7 хувийг ашиглаагүй байна.


2. ЖДҮ-ийн төслийг сонгон шалгаруулахдаа дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, санал өгөөгүйгээс дэмжигдсэн төслүүд арилжааны банкны шалгуурыг хангахгүй байна.

3. ЖДҮХСангаас арилжааны банкаар дамжуулан 807.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 25 зээлдэгчийн 92 хувь нь үйл ажиллагаа явуулсны үр дүнд 51 ажлын байр хадгалагдаж, 68 ажлын байр шинээр бий болсон нь ЖДҮХС-гийн зээл нь орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулахад зохих үр дүн өгч, зээл зээлийн хүүгийн эргэн төлөлт хэвийн байна.

4. ЖДҮ-ийг дэмжих сангаас олгосон зээлийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс 95,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 2 төсөл хэрэгжүүлэгч зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна

5. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн нь ЖДҮ-ийн сангаас олгосон зээлийн тайлан, ажлын байрны мэдээг тухай бүр нь гаргаж албажуулан, Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлээгүй байна

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2017.06.12

Баянхонгор хот

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1а/399 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу Жижиг, дунд үйлвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа

1. Төсөл сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, дэд комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

Хоёр. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. ЖДҮ-ийн төслийг сонгон шалгаруулахдаа дэд комиссын гишүүд төсөлд нэг бүрчлэн үнэлгээ хийж, хэрэгжих боломжтой төслийг сонгон шалгаруулж, эх үүсвэрийг бүрэн ашиглах.

2. Аймгийн Засаг дарга, арилжааны Хас банкт байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу орон нутгийн орлогоос байршуулсан 75,0 сая төгрөгийн эх үүсвэрээс тооцогдох хүүгийн орлогыг хэрхэн зарцуулах асуудлыг шийдвэрлэж, гэрээг шинэчлэн байгуулах.

3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих дэд комиссын ажлын тайланг жил бүр хэлэлцэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Гурав.Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Баттөр, ЖДҮ-ийг хариуцсан
мэргэжилтэн Б.Оюунцэцэг нарт

1. “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын дагуу хөнгөлөлттэй зээлийн дэлгэрэнгүй мэдээ, судалгааг хугацаанд нь гарган албажуулж, Сангийн яамны ЖДҮ-ийн газарт хүргүүлэх.

2. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн С.Талстболор, Д.Нямхүү нарыг төсөлд тусгагдсан үйл ажиллагааг явуулахад хяналт тавьж, хэрэгжилтийг дэд комисст тайлагнах.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 10-р сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. МӨНХБАТ